

Ц.Бямбарагчаа - Удирдлагын академийн Онцгой
байдлын удирдлага, стратегийн профессорын
багийн профессор, доктор (PhD), хурандаа

МОНГОЛЫН НҮҮРСНИЙ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙХ ШИНЖИЛГЭЭ

Хураангуй. Нүүрс нь хар, хар хүрэн өнгөтэй, амархан шатдаг нэгэн төрлийн "" шиг өнгөтэй чулуу юм. Нүүрс нь дээд ургамалын үлдэгдэл хүлэрээс үүсэх ба дотроо хүрэн нүүрс, чулуун нүүрс, антрацит гэсэн төрөлд хуваагдана. Бүрдүүлэгч үндсэн химийн элемент нь нүүрстөрөгч, устөрөгч бөгөөд, хүчилтөрөгч, хүхэр, азот тодорхой хэмжээгээр агуулагдана. Нүүрс нь эрчим хүчний үндсэн эх үүсвэр бөгөөд нүүрсний ордыг ил болон далд уурхайгаар ашиглана.

Нүүрс нь Дэлхийн хэмжээнд цахилгаан эрчим хүч гарган авах хамгийн гол түүхий эд бөгөөд мөн нүүрстөрөгчийн давхар исэлийн гол үүсвэр болж байна. CO₂ нь хүлэмжийн хий бөгөөд цаг уурын өөрчлөлт, Дэлхийн дулаарлын гол шалтгаан гэж үзэж байна. Нүүрсийг шатаах явцад байгалийн хийнээс хоёр дахин их, газрын тосноос арай илүү хэмжээний CO₂ ялгардаг байна.

Түлхүүр үг. Уул уурхайн салбар, нүүрс

Оршил

Монгол улс ашигт малтмал, эрдэс баялгаараа арвин их нөөцтэй орон билээ. Тухайлбал манай орны нүүрсний геологийн нөөц 162.3 тэрбум гэж тогтоогдсоноор нөөцийнхөө хэмжээгээр дэлхийн эхний 10 орны тоонд багтдаг болсон. Сүүлийн жилүүдэд ашигт малтмал олборлолт, экспортын хэмжээ ч огцом нэмэгдэж уул уурхайн салбарыг Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбараар тодорхойлоод байна. Уул уурхайн салбар ДНБ-ний 20%, нийт экспортын 90%, аж үйлдвэрийн 60%, төсвийн орлогын 30%-г тус тус эзэлж байна. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг технологийн агууламжаар нь аваад үзвэл 96 хувь нь түүхийгээр ямар ч боловсруулалтгүйгээр зах зээлийн үнээс хэт доогуур экспортонд гарч байна.

Тиймээс улс орны тэргүүлэх салбар болсон уул уурхайн салбар тухайлбал нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг чухалчлахаас гадна экспортын үр ашгийг дээшлүүлэх тухай асуудалд мөн анхаарлаа хандуулах хэрэгтэй байна. Манай улсын гадаад харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулах үйлст нүүрсний экспорт чухал хувь нэмэр оруулж байгаа ба өнөөгийн түвшинд нүүрсний салбарыг хөгжүүлэх нь олон салбарын зангилаа, гео-эдийн засгийн огтлолцол дээр оршиж буй харилцааны бодлого, төлөвлөлтийн тулгамдсан асуудал болсон. Иймд нүүрсний экспортыг нэмэгдүүлэх бодлого төлөвлөлтийн асуудлыг дан ганц эдийн засгийн ашиг

сонирхол талаас нь бус харин улс төр, эдийн засаг, нийгмийн бусад олон талын нөлөөллийг нэгтгэн авч үзсэн оновчтой, алсын хараатай, уян хатан стратеги бодлого боловсруулах бодит хэрэгцээ, шаардлага урган гарч байна.

Үндсэн хэсэг

Монгол Улс 2020 онд дэлхийн 149 оронтой худалдаа хийж гадаад худалдааны нийт бараа эргэлт 12870.3 сая ам.доллар болж 2019 оны гүйцэтгэлээс 876.9 сая ам.доллар буюу 6.4 хувиар буурчээ. Экспортын дүн импортын дүнгээс 2282.4 сая ам.доллараар давсан үзүүлэлттэй байна. Экспортод 7576.3 сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувиар буурсан байна.

Монгол улс дэлхийн 75 оронд бараа экспортлосноос БНХАУ-д 72.5 хувь, Швейцард 22.2 хувь, Их британид 1.1 хувь тус тус ногдож нийт экспортын 95.8 хувийг дээрх орнууд эзэлж байна. 2020 онд эрдэс бүтээгдэхүүний экспортын 96.2 хувийг чулуун нүүрс, зэсийн баяжмал, молибдены баяжмал, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайрын хүдэр болон боловсруулаагүй нефтийн экспорт эзэлж байна.

Нүүрс: 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулахад чулуун нүүрсний экспорт 7879.7 мян.тонноор, үнийн дүн нь 950.7 сая ам.доллараар, хилийн дундаж үнэ нь 10.0 ам.доллараар тус тус буурчээ. 2020 онд чулуун нүүрсний 95.2 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Нефть: 2020 онд боловсруулаагүй нефтийн экспорт 4070.5 мянган баррель буюу 150.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 2474.7 мянган баррелиар, үнийн дүнгээр 215.8 сая ам.доллараар тус тус буурсан байна. 1 баррель нефтийн дундаж үнэ 56.0 ам.доллараас 37.1 ам.доллар болж буурчээ.

Зэсийн баяжмал: 2019 онтой харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 8.6 мянган тонноор, хилийн дундаж үнэ нь 4.9 ам.доллараар, үнийн дүн нь 17.9 сая 24 ам.доллараар тус тус буурчээ. 2020 онд зэсийн баяжмалыг 100.0 хувь БНХАУ-д гаргасан байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн экспорт 8.2 сая тоннд хүрч, 2019 оны дүнгээс 246.5 мянган тонноор буурсан байна. Экспортын дундаж үнэ нь 78.0 ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оныхоос 9.8 ам.доллараар нэмэгджээ. Төмрийн хүдрийг 100.0 хувь БНХАУ-д экспортлосон байна.


Манай улсын хувьд ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт 2002 оны байдлаар нийт экспортын 50 орчим хувийг эзэлж байсан бол өнөөдөр 90 орчим хувийг эзэлж байна. Цаашид ч энэхүү хандлага хэвээр хадгалагдахаар байгаа бөгөөд стратегийн ач холбогдол бүхий томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын үе шат дуусч олборлолтын үйл ажиллагаа эхэлснээр ашигт

малтмалын бүтээгдэхүүний экспорт манай улсын нийт экспортын 98 хүртэл хувийг эзлэх хандлагатай байна.

Монгол улсын нүүрсний нөөц, баялгийн тархалт: Монгол улсын нүүрсний геологийн таамаг нөөц 173,3 тэрбум тонн, цаашдаа нэмэгдэх магадлалтай. 20 гаруй тэрбум.тонн нүүрсний нөөц нарийвчилсан хайгуулын үр дүнгээр баталгаажсан ба 5 бүс, 15 сав газрын хүрээнд 300 орчим нүүрсний орд, илрэл байгаа бөгөөд 85 орчим 26 ордод хайгуулын нарийвчилсан судалгаа хийж, үнэлгээ өгсөн, манай орон нүүрсний нөөцөөр дэлхийн эхний 10 орны тоонд багтаж байна. Нүүрс нь монгол орны нутаг дэвсгэрт харьцангуй жигд тархмал байдаг. Нутгийн зүүн, хангайн бүсэд хүрэн нүүрс, төв бүс нь хүрэнээс коксжих нүүрс рүү жилжих завсрын үе, баруун болон говийн бүсэд чулуун болон коксжих нүүрс зонхилж тархсан байдаг.35

Дотоодын нүүрсний хэрэгцээ: Цахилгаан, дулууны үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтын нүүрсний хэрэгцээг улсын болон хувийн хэвшлийн нүүрсний уурхайнуудаас хангаж байдаг. Нийт олборлосон нүүрснийхээ 73,7%-г БНХАУ руу экспортлож 26,3%-г дотооддоо хэрэглэжээ.

Нүүрсний хэрэглээний бүтэц



Цаашид төрөөс нүүрсний салбарт баримталж буй хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ба татварын бодлогын дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Нүүрсийг боловсруулах
- Нүүрсний салбарыг зам тээврийн бодлогоор дэмжих нь
- Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого
- Хууль эрх зүйн орчин нь ил тод, тодорхой байх
- Татварын орчин нь өрсөлдөх чадвартай, тогтвортой, тэгш үйлчлэх
- Хэрэгжүүлэх чадавхи бүхий төрийн цогц үйл ажиллагаатай байх
- Байгаль орчинд ээлтэй удирдлагын зөв механизмаар ажиллах явдал

юм.

Манай улсын хууль эрх зүйн тогтворгүй байдал нь хүнд аж үйлдвэрийн салбарт гадаадын хөрөнгө оруулалт татахад том саад болдог. Тухайлбал:

Монгол улсын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн 48 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн мэдэлд байгаа ба эрсдэл багатай төдийгүй ямар нэгэн улс төрийн шийдвэр гарахад шууд орхиод явах боломжтой байдаг.

Харин хүнд аж үйлдвэр нь асар их хөрөнгө оруулалт шаарддагаас гадна урт хугацаанд зардлаа нөхдөг учир энэ салбарт төрийн тогтвортой бодлого чухал юм. Олон жил уйгагүй ажиллаж ашиг олох тэдний бизнест гэнэтийн шийдвэр гаргахгүй гэх баталгаа хэрэгтэй ба одоогийн байдлаар манай төр баталгаа гаргах чадваргүй байна. Энэ нь сонгуулийн дараа Засгийн газрын залгамж халаа байхгүй болох, хууль хэрхэн яаж өөрчлөгдөхийг урьдчилан хэлэх боломжгүй байдалтай шууд холбоотой юм. Тиймээс Монголын уул уурхайн салбарт хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд том хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт шаардлагатай учир хууль эрх зүйн орчинг дэлхийн жишгийн дагуу ил тод, тодорхой, тогтвортой, тэгш үйлчлэх бодлого баримтлах шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар экспортлосон нийт нүүрсний ихэнх хувийг “Чинхуа-Нарийн сухайт” ХХК, “МАК” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК, “Тавантолгой” ХК, “Тавантолгой транс” ХХК, “Энержи ресурс” ХХК зэрэг компаниуд эзэлж байгаа бөгөөд Монгол Улсын Гашуун Сухайт, Шивээхүрэн боомтуудаар авто тээврийн хэрэгслээр БНХАУ руу гаргаж байна. Энержи ресурс” компани авто зам барьсан хэдий ч уг зам нь жилдээ 18 сая тонны хүчин чадалтай ба нүүрсний олборлолт, экспортын хэмжээ нэмэгдсээр байгаа тул хүчин чадал нь дутагдалтай байна. Авто замаар тээвэрлэлт явуулах нь асар өндөр зардалтай байдаг ба тиймээс төмөр замын асуудлыг нэн яаралтай шийдэх шаардлагатай байна.

Төмөр замын тээвэр нь их хэмжээний ачааг алсын зайд байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр тээвэрлэх боломж олгодог тээврийн төрөл тул аливаа улс орны уул уурхайн салбарт өргөнөөр ашиглагддаг. Манай улсын Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр, Шарын гол, Багануур, Шивээ- Овоо, Адуунчулууны нүүрсний уурхай, Бор-Өндөр, Өргөний хайлуур жоншны уурхай төмөр замын сүлжээнд холбогдсон бөгөөд эдгээр уурхай, үйлдвэрийн түүхий эд болон бүтээгдэхүүний тээвэрлэлтийг төмөр замаар дагнан гүйцэтгэж байна. Үүнийг “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-оор УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батласан байдаг.

Дүгнэлт

Монгол улсын нүүрсний экспорт сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа хэдий ч нүүрсэндээ боловсруулалт хийлгүй түүхийгээр нь гаргаж байгаа учир зах зээлийн үнээс хэт доогуур байна. Цаашдаа түүхий эд нийлүүлэгчийн байр сууринаас бус нүүрсээ боловсруулж экспортонд гаргах нь манай улсын эдийн

засагт үр ашигтай болох нь судалгаагаар харагддаг.

Уул уурхай, нүүрсний салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирсээр байгаа боловч баримталж буй төрийн бодлого эмх замбараагүй, эрх зүйн орчин тогтворгүй байна. Мөн татвар нь бизнесийг дэмжиж зохицуулах бус ердөө төсвийн орлогыг бүрдүүлэх л зорилго үүрэгтэй байна.

Дэд бүтэц, хил боомтын хүчин чадал муу байгаа ба нүүрсний салбарын ашигтай ажиллагаа нь тухайн улсын дэд бүтэц буюу төмөр замтай нягт холбоотой байдаг. Учир нь нүүрсний өртөгийн ихэнх хувийг тээвэрлэлтийн зардал эзэлдэг.

Нэг импортлогч орны хараат, энэ нь зах зээлийн үнээс хэт доогуур Хятад улсын хэлсэн үнээр нүүрсээ экспортлоход хүргэдэг. Нүүрсний эрэлт хэрэгцээ нэмэгдэж буй өнөө үед Хятад улсаас гадна Номхон далайн орнууд болох Япон, БНСУ зэрэг гуравдагч зах зээл рүү нүүрсээ экспортлох боломж нээлттэй байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Уул уурхайн олборлох, эзэмших эрх олон жижиг компаниудын мэдэлд байна. Тус тусдаа үйл ажиллагаагаа явуулж байгаа учир эдийн засаг болон бусад талаараа өрсөлдөх чадвар муу байна. Өнөөдөр манай нүүрсний экспорт үндсэндээ нэг зах зээлээс хараат байгаа нь Монгол нүүрс үнэ цэнээ алдах, хямд үнээр борлогдох гол нөхцөл болж байна. Иймд Монголын нүүрсний экспортын үр ашгийг нь дээшлүүлэхэд экспортын хоёр гарцтай байх асуудал стратегийн чухал ач холбогдолтой ба үүнтэй уялдаж төмөр замын дотоодын сүлжээг өргөтгөн хөрш орнуудын сүлжээтэй холбох асуудал Монгол улсын төр засгийн тулгамдсан асуудал болжээ.

Монголын нүүрсний үнэ цэнийг дээшлүүлэх дараагийн чухал асуудал бол Нүүрсийг дотооддоо боловсруулж экспортлох явдал юм. Үүний тулд Монголын нөхцөлд тохирсон байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд үр өгөөж бүхий кокс боловсруулах технологийг нэвтрүүлэх нь нүүрсний экспортын чанарт нөлөөлж үнэ цэнийг нь өсгөх үр ашгийг нэмэгдүүлэх ялангуяа тээвэр, логисткийн зардлыг бууруулахтай холбоотой юм.

Санал

Нүүрсний салбарт төрөөс оновчтой цогц бодлого авч явуулах шаардлагатай ба гарсан шийдвэрүүдийн хэрэгжүүлэлтийг хурдасгах, уул уурхайн салбарт эрх зүйн тодорхой, тогтвортой байдлыг нэн даруй тогтоох;

Манай улсын нүүрсний нөөц 162,3 тэрбум тонн үүний 100 орчим тэрбум тонн нь хүрэн нүүрсний нөөц гэж тогтоогдсон ба хүрэн нүүрсний ордууд байрлалын хувьд зүүн бүсэд ихэвчлэн байдаг. Тиймээс “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборт эдгээр хүрэн нүүрсний ордууд дээр тулгуурласан “Хагас коксын үйлдвэр”, нүүрсийг шингэрүүлэн түлшний үйлдвэр барих;

БНХАУ, ОХУ нь ДХБ-ийн бүрэн эрхэт гишүүн орон болсон тул хоёр

хөрш оронтой хийх “Нүүрсний худалдаа”, тэдгээр орны газар нутгаар дамжин нүүрсийг далайн боомтод хүргэж тээвэрлэх асуудлыг ДХБ-гийн үндсэн зарчимд нийцүүлэх;

Эдийн засгийн дипломат үйл ажиллагааны хүрээнд Орос, Хятад, Монгол улсын хооронд дамжин өнгөрөх тээврийн 3 талт хэлэлцээрийг байгуулах нь нүүрсний экспортыг хоёр гарцтай болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. “Нүүрсний судалгааны хэлтэс” АМГТГ
 2. “Эрдэс баялагийн статистик мэдээ” 2020
 3. “Экспортлогдсон Чулуун нүүрсний судалгаа” 2020
 4. Н.Батнасан ‘Гадаад худалдаа’, УБ, 2003
 5. Д.Авирмэд “Олон улсын худалдаа ба эдийн засаг” УБ.2008
 6. “Э.Гүргэмжав “Олон улсын худалдаа”, УБ, 2004
 7. Л. Очирбат, Л.Пүрэв, Ж.Лхамсүрэн, Д.Чулуун, Сун Юун Сонь “Монгол орны геологи уул уурхайн ном” 2008 он
 8. Я. Гомбосүрэн “Эрдэс баялгийн олборлолт, боловсруулалтын технологи эколог эдийн засгийн үнэлгээний онол аргазүй” 2004 он
 9. Г.Даваажав “Олон улсын худалдааны эрх зүйн зохицуулалт” 2007 он
 10. МУХАҮТ “Экспорт, импортын гол нэрийн барааны дэлхийн зах зээлийн 2011 оны төлөв байдлын тухай илтгэл”
 11. АМГТХЭГ “Эрдэс баялгийн зах зээлийн судалгаа дүгнэлт 2008.06
 12. АМГ Нүүрс судалгааны хэлтэс “Монгол улсын нүүрсний салбарын өнөөгийн байдал” 2012 он
- Гадаад эх сурвалж:
1. Asian development bank, How to desing, negotiate, and implement a Free trade agreements in Asia, 2008
 2. Intematioal Trade Center, Business guide to the World Trading System, 1999
 3. Negotiating World Economy, Odel 2000